

# ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТ

Эмч, шүдний эмч, эм зүйч

**ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТ** нь Европын Холбооноос гадуур эмч, шүдний эмч, эм зүйч мэргэжлээр мэргэжлийн боловсрол эзэмшсэн, Чех улсын нутаг дэвсгэрт (эсвэл ЕХ-ны өөр гишүүн улсад) энэ мэргэжлээр ажиллах хүсэлтэй хүн бүрийн заавал өгөх ёстой шалгалт юм. Шалгалт нь энэ мэргэжлийг гүйцэтгэх чадварыг харуулахад зориулсан.

- **Өргөдөл болон өргөдлийн бүх бичиг баримтыг шуудангаар болон өөрийн биеэр хүргүүлж болно.**
  - **Хаяг:** Эрүүл мэндийн яам - Ministerstvo zdravotnictví (Palackého náměstí 4, Прага 2, 128 01)
- **Шалгалт бүхэлдээ зөвхөн чех хэл дээр явагдана!**
- **Гурван хэсгээс бүрдэнэ.**
- **Өргөдөл гаргагч бүрд шалгалтын огноог (бичиг эсвэл ам хэсэг) урилгаар явуулах бөгөөд энэ нь өргөдөлд заасан холбоо барих хаяг руу баталгаат шуудангаар илгээгдэнэ.**
- **Шалгалт нь өргөдөл гаргаснаас хойш 30 сарын дотор хийх ёстой.**
- **Өргөдөл гаргагч нь эмчийн мэргэжлээр ажиллах мэргэжлийн үр чадварыг хүлээн зөвшөөрүүлэх, зөвшөөрлийн шалгалтад орох хүсэлтийг дээд тал нь таваас удаа гаргаж болно.**

## Шалгалтын хэсгүүд:

- 1. Шалгалтын бичгийн хэсэг (хоёр шалгалт)**
  - a. **Мэргэжлийн мэдлэгийг баталгаажуулах шалгалт.**
  - b. **БНЧУ-ын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой эрүүл мэндийн тогтолцоо болон үндсэн хуулийн талаарх мэдлэгийг шалгах шалгалт.**
  - Шалгалт бүрээс доод тал 70% -ийн оноо авах шаардлагатай.
  - Бичгийн шалгалт хоёулаа нэг өдөр явагдана.
  - Шалгалтуудыг амжилттай өгөх нь шалгалтын 2 дахь дадлагын хэсгийг өгөх урьдчилсан нөхцөл юм.
- 2. Шалгалтын дадлагын хэсэг (дадлага) – эмч, шүдний эмч, эм зүйчийн шууд мэргэжлийн удирдлага дор 6 сарын хугацаанд магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагад явагдана (ажлын цагийг нь шалгалтын дадлага хэсэгт багтаж холбогдох боловсролын хөтөлбөрөөр тодорхойлно).**
  - Дадлагын хугацаанд нэр дэвшигч 5 хэрэг боловсруулах ёстой бөгөөд үүнээс шалгалтын комисс 1-ийг сонгож, аман шалгалтын үеэр хамгаална.
  - Дадлага хийж дууссаны дараа өргөдөл гаргагч нь дадлага хийж дууссан гэсэн гэрчилгээ авна.
    - Хэрэв та дадлага хэсэгт тэнцээгүй бол мэргэжлийн үр чадварыг хүлээн зөвшөөрөхгүй байх шийдвэр гарснаас хойш 1 жилийн дараа давтан хийж болно.
    - Өргөдөл гаргагч нь шалгалтын аман хэсгийг бөглөсөн өргөдлийн хамт дадлагын хэсгийг гүйцэтгэсэн баталгааг яаманд илгээнэ.




Spolufinancováno  
Evropskou unií



MINISTERSTVO VNITRA  
ČESKÉ REPUBLIKY



Projekt "Centrum na podporu integrace cizinců v Ústeckém kraji" reg. č. CZ.12.01.02/00/23\_008/0000008 je financován OP AMIF a MV ČR.



# ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТ

Эмч, шүдний эмч, эм зүйч

- Гурав дахь аман шалгалтыг өгөх зөвшөөрлийн урьдчилсан нөхцөл нь дадлага хэсгийг амжилттай дүүргэх явдал юм.

Магадлан итгэмжлэгдсэн байгууламжуудын тойм:

- эмчийн зөвшөөрөх шалгалтыг [эндээс](#),
- шүдний эмчийн зөвшөөрөх шалгалтыг [эндээс](#),
- эм зүйчийн зөвшөөрөх шалгалтыг [эндээс](#).

3. **Шалгалтын аман хэсэг** – Чех хэлээр өөрийгөө илэрхийлэх чадварыг багтаасан мэргэжлийн мэдлэгийг шалгалтын комисс шалгана.
- Хэрэг боловсруулах судалгааны хамгаалалт нь тусдаа хэсэг гэж тооцогддог.
    - Хэрэв судалгааг хамгаалж чадаагүй ч гэсэн оролцогч аман шалгалтаа үргэлжлүүлж болно. Оролцогч аман шалгалтад тэнцсэн тохиолдолд мэргэжлийн үр чадварыг хүлээн зөвшөөрөхгүй байх шийдвэр гаргана. Харин дараагийн оролдлогод тэрээр зөвхөн хэрэг боловсруулах судалгааг хамгаалах болно.

## Шалгалтын хураамжууд

	Бичгийн хэсэг	Аман хэсэг
4. оролдлого	3 000 Kč	4 000 Kč
5. оролдлого	4 000 Kč	6 000 Kč
6. дараагийн оролдлогууд	6 000 Kč	9 000 Kč



## Өргөдөлд багтсан бичиг баримтууд:

- гадаад мэргэжлийн боловсролын баримт бичгийн албан ёсны баталгаажуулсан орчуулга (их, дээд сургуулийн диплом);
- ерөнхий анагаах ухаан, шүдний эмчилгээ, эм зүйчийн чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн анагаахын магистрын зэрэг олгох хөтөлбөрт тэнцэх **дээд боловсрол эзэмшсэн гадаадын дээд боловсрол, мэргэшлийг БНЧУ-д хүлээн зөвшөөрсөн гэрчилгээний албан ёсоор баталгаажуулсан хуулбар** (боловсролын харьцуулалт=nostrifikace);
- **өргөдөл гаргагчийн эрүүл мэндийн байдлыг нотлох баримт** - холбогдох эмчийн мэргэжлээр ажиллах эрүүл мэндийн талаарх эмнэлгийн дүгнэлт.
  - дүгнэлт нь 3 сараас дээш хугацаатай байж ёсгүй;
- **өргөдөл гаргагчийн гэмт хэрэгт холбогдож байгаагүйг нотлох баримт**
  - дүгнэлт нь 3 сараас дээш хугацаатай байж ёсгүй;
- **биеийн байцаалтын үнэмлэхийн хуулбар** (баталгаагүй);
- **гэрлэлтийн гэрчилгээний албан ёсоор баталгаажуулсан хуулбар эсвэл овог нэр өөрчлөгдсөнийг нотлох баримт** (хэрэв өргөдөл гаргагч овог нэрээ өөрчилсөн бол);




Spolufinancováno  
Evropskou unií



MINISTERSTVO VNITRA  
ČESKÉ REPUBLIKY



Projekt "Centrum na podporu integrace cizinců v Ústeckém kraji" reg. č. CZ.12.01.02/00/23\_008/0000008 je financován OP AMIF a MV ČR.



# ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТ

Эмч, шүдний эмч, эм зүйч

- захиргааны хураамж төлсөн баримт (2000 крон)
  - o марк хэлбэрээр эсвэл ЭМЯ-ны дансанд шилжүүлэн төлж болно.

## Хэзээ өргөдөл хүсэж мөн хэзээ бүртгэлдүүлдэг вэ?

ХҮСЭЛТ (эрүүл мэндийн холбогдох мэргэжлийг хэрэгжүүлэх мэргэжлийн үр чадварыг хүлээн зөвшөөрөх өргөдлөө)	БҮРТГЭЛ
Өргөдөл гаргагч нь батламж олгох шалгалтыг анх удаа өгөх, давтан (амжилтгүй өгсний дараа) эсвэл өргөдөл гаргах захиргааны ажиллагааг шийдвэрээр зогсоосон тохиолдолд хүсэлт өгнө.	Аль хэдийн өргөдөл гаргасан оролцогч бүртгэлийг өгөх ба зөвшөөрлийн шалгалтын бичгээр болон аман хэсэгт орохоор төлөвлөж байгаа, мөн зөвшөөрлийн шалгалтын холбогдох хэсгээс чөлөө авсны дараа, эсвэл батлах шалгалтын дадлагын хэсгийг амжилттай өгсний дараа шалгалтын аман хэсэгт орохоор төлөвлөж байгаа оролцогч өгнө.

Шалгалтын бичгээр болон амаар өгөх хэсэгт тодорхой огноо бүхий урилгыг оролцогчид илгээнэ. Хэрэв та ноцтой шалтгааны улмаас заасан өдөр оролцох боломжгүй бол бичгээр уучлалт гүйх ёстой (цахим шуудангаар биш!). Зөвшөөрлийн шалгалтын дадлага хэсгээс шалтаг тооцохыг зөвшөөрөхгүй.

## Зөвшөөрлийн шалгалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллүүд:

<https://www.mzcr.cz/category/veda-a-lekarska-povolani/akreditace/>



<https://www.ipvz.cz/lekari-zubni-lekari-farmaceuti/aprobacni-zkousky/zakladni-informace-o-aprobacnich-zkouskach>



<https://www.nconzo.cz/cs/aprobacni-zkouska>



Spolufinancováno  
Evropskou unií




MINISTERSTVO VNITRA  
ČESKÉ REPUBLIKY



Poradna  
pro integraci

Projekt "Centrum na podporu integrace cizinců v Ústeckém kraji" reg. č. CZ.12.01.02/00/23\_008/0000008 je financován OP AMIF a MV ČR.




# ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТ

Эмч, шүдний эмч, эм зүйч

Эрүүл мэндийн яамнаас Сувилахуйн болон эмнэлгийн бус мэргэжлийн үндэсний төвд (NCO NZO) эмнэлгийн бус мэргэжлээр мэргэшүүлэх зөвшөөрөл олгох шалгалтыг даалгасан.

Бид нэмэлт мэдээлэл бэлтгэж байна.

## PRŮBĚH APROBAČNÍ ZKOUŠKY



Spolufinancováno  
Evropskou unií



MINISTERSTVO VNITRA  
ČESKÉ REPUBLIKY



Poradna  
pro integraci

Projekt "Centrum na podporu integrace cizinců v Ústeckém kraji" reg. č. CZ.12.01.02/00/23\_008/0000008 je financován OP AMIF a MV ČR.